

**“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2026 оны 02 сарын 14 өдөр

№ 01/2026

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай:

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 28-р тогтоол, “Түмэн шувуут” Хувьцаат компанийн дүрмийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Түмэн шувуут” ХКомпанийн 2025 оны цэвэр ашгийн 30 хувийг Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Нэгж хувьцаанд 21.8 нэгж хувьцаа төгрөгийн ашиг тараахыг Гүйцэтгэх захирал /Ж.Болд/ болон ерөнхий нягтлан бодогч Н.Должинсүрэн нарт үүрэг болгосугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
4. Ногдол ашгийг “ҮЦТХ” ХХК-тай гэрээ байгуулан хувьцаа эзэмшигчдэд 2026 оны 04 сарын 30-ны өдрийн дотор мөнгөн хэлбэрээр тараасугай.
5. Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Ж.Болд/-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН

Д.ЭРХЭМБАЯР

